

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэвэгийн Гомбожав	Дугаар	L092
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Дархан
Төрсөн газар	Дархан сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ахай бэйсийн хүрээ, Энгэр шандын хурал	Сүм хийдийн дугаар	ХЭДР 024 ХЭДР 029
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 20	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Дархан сумын Ахай бэйсийн хүрээ, Энгэр шандын хурал

-Бид нар хуучин сүм хийдүүдийн судалгааны ажлаар явна. Дархан суманд байсан 1937,38 оноос өмнөх хуучин сүм хийдүүдийн тууриудыг үзэж, газар зүйн хэмжээг тогтоож, зураг хөргийг нь авч баримтжуулж бас хүмүүсээс дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилготой явж байгаа юм. Та өөрийн мэдэх сонссон дуулсан зүйлээсээ бидэнд ярьж өгөхгүй юу?

Би энэ хийдэд(Ахай гүний хийдэд) сууж байсан юм. 5настайдаа лам болсон. Тэгээд дараа нь Энгэр шандад очиж байсан. Тэгэхээр Ахай гүний хийд нь 300 гаран ламтай нэлээд хэдэн дугантай хийд байсан. Ламрим, Чойр, Ганжуур, Чогчэн Хайлан, Манба дуган гэж байсан. Ийм 6,7 дуган байсан. Ганжуур шүтээн нь гол шүтээн шүтээн. дуган гэж байсан.

-Ахай гүний хийд хэдэн онд байгуулагдсан юм болоо?

Тэрийг би яаж мэдэхэв. 5 настай хуралд сууж байсан юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Онцлог хурлууд Хайлан, Чойр гээд хурдаг байсан биз дээ?

Хайлан хурдаг байсан. Ламрим дуганд Ламрим хурдаг байсан юм. Чойр гэж хурдаг байлаа.

-Чойр дуганд гавж, гэвшийн дом барьдаг байсан уу?

Барьдаг байсан. Чойрт барина шүү дээ. Тэгээд Ганжуур дуган гэж нэг дуган байсан. Модон дуган. Ер нь буулгаж чадахгүй сүүлд арваад буулгасан даа. Ихээ том сараалжин дуган байсан. Хана гүйлгээд бүрээс нөмөргөдөг. Энгэрийн шандны хурал гэдэг Ноён гэгээний хийдээс хэдэн лам явж майдар залж ирж Цогчэн хурал байгуулсан.

-Ахай гүний хийдэд таны шавилан сууж байсан үеийн хамба, гэсгүй, унзадуудын нэрийг санаж байна уу?

Өвгөн хамба Лувсаннэрэн гэдэг хамгийн том хамба байсан. Тэрнээс хойш Чүлтэм гэж нэг хамба байсан. Манай эцэг энд Да лам байсан юм. Сүүлд Энгэрийн Шандын хуралд дэд ламаар шилжиж тэнд хурал байгуулж байсан юм.

-Унзад нь Жигмэд унзад гэж байсан уу?

Аан Жигмэд унзад гэж миний багш лам байж байгаад нас барсан юм. Их унзад нь Гонио унзад гэж байсан. Дэд унзад нь тэр манай багш. Тэрний доод унзад нь Дагвын Шарав гэж байсан. Тэгээд доошоо бага унзадууд байсан даа. Доошоо Тангад Жигмэд, Шарав, Чойжив гэж байсан.

-Яг хэдэн онд баларсан бэ? 1937 онд уу?

Хэдэн онд баларсныг сайн мэдэхгүй. Би 18-тай хар болж байсан. Тэрнээс хойш удахгүй хурал хаагдаж байсан.

-Ахай гүний хийдийн гол Цогчэн дуганыг буулгалгүй одоо болтол байгаа юм байна?

Тийм. Хөөрхөн давхар сүм байсан. Ахай бээсийн гол дуган.

-Чойр дацан нь аль игчааны сургалттай байсан бэ?

Тэрийг мэдэхгүй. Чойр дацан чинь гавжийн дамжаатай, домд мордчихдог тийм л байсан. Гавж боллоо л гэдэг. Дом тавилаа л гэдэг. Тэр хоёрт л ажиллаж байсан. Хайлан гэдэг юу гэхээр гэцэл, гэлэнгүүд, 45 хоног айлдлага уншаад гавъяа дарна гэж тэр урагшаа хонхор гэдэг газар юмаа аваачиж уншиж хийж байсан. Дүлцэнгийн шороо гэдэг чинь тэндээс гарч байсан юм.

-Хайландаа Дүйнхор залдаг байсан уу?

Дүйнхор гэж ярьдаггүй байсан.

-Хайлангаа намар хийдэг байсан уу?

Тийм. Гавъяа зална гээд сэрүүн орсон үед л хийдэг байсан.

-Майдар эргэж нүгнээ сахидаг байсан уу?

Майдар эргэдэг байсан. Майдар Ганжуур хурахлаар эргэдэг байсан. Алтан Ганжуур гэж хурдаг, Арван хоног маань гэж хурдаг байлаа.

-Маанийн бүтээл хийдэг байсан байх нь?

Тийм. Дүнчүүр маань уншиж байсан биз дээ. Маанийн бүтээл гэдэг нь маань мэгзэмээ бүгд үзээд үрэл нь бумбаа дүүрдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тийм тийм. Тэгээд лам нар нь маань тоолоод?

Тийм тэгээд тэр их сайн үрэл байдаг байсан байх.

-Жанрайсагийн үүднээс хийдэг байсан байх л даа?

Хэн мэдэхэв. Жанрайсаг гэж ярьдаггүй л байсан. Жанрайсаг ч байж л байсан л даа. Бишгүй суварга бий.

-Ахай гүний Гачин Лувсанням гэдэг хүнийг та мэдэх үү?

Мэдэхгүй. Лувсаннэрэн гэж нэг хамба байсан. Өвгөн хамба гэж байсан баригдсан даа.

-Ахаа гүний хийдийн уул ус, тахилгын номыг бичиж байсан ламын талаар та дуулсан уу? Дархан хан уулын сан тахилгыг Ахай гүн гэдэг хүн хүсэлт гаргаж Гачин Лувсанням гэдэг бичсэн гэж байна.

Үгүй ээ. Ахай гүн гэдэг чинь нэг ноёны л нэр байх. Тэгээд Ганжуураа хурахдаа уул овоогоо тахина, Ганжуураа залаад нутгаа эргэдэг, Ахай гүний нутгаар эргэн тойрон явдаг байсан.

-Одоо тэр овоо энэ тэр нь мэдэгдэхүйц байдаг л юм байх? Ахай гүний хилийн дээсийг тэмдэглэсэн мэдэгдэхүйц овоо бий юу одоо?

Уулан дээрээ уг нь овоо зассан юм. Хойно Эрхтий гэдэг уулан дээр нутгийн дээсний овоо бий. Тэр уулан дээр хоёр овоо байгаа. Нэг нь гадаадынх, нэг нь манайхных. Жаахан ийшээ яваатахаар Хашаатын цагаан толгой гэдэг дээр бас байна уу үгүй юу. Баруун Цайдамын цаагуур ороод Бэрхт уул гэж хаа байна Тэр хүртэл явсан байдаг юм.

-Маарамба лам нар байсан уу?

Байсан байлгүй яахав. Би жаахан байсан. Мамба нь эм барьдаг, Чойр нь дагсал, Чойрын ном үздэг байсан. Хайлан бол яахав. Жилдээ нэг. Ламрим гэж хааяа нэг хурчихдаг дацан байсан. Ганжуурт ганжуураа хураад мааниа хурвал хураад тэгээд тардаг байсан

-Өөр онцлог хурал хүрж байсан уу? Улирлын чанартай ч юмуу?

Сар шинийн үеэр Цэдэр лхам гэж хүрж байсан. Хуучин хурал гэж хүрж байсан. Балин тахил хийгээд адислаж байсан байх.

-Хуучин хурал, Цэдэрлхам тэгээд 15ны ерөөлөө хурна тиймээ?

Битүүнд Цэдэр лхамаа хураад хорин хэднээс балин адислаж байсан байхаа.

-Хуучин хурлаа 3 хоног хурдаг байсан уу? 5хоног хурдаг байсан уу?

25-аас эхэлж хурдаг байсан байхаа. Хуучин хурал гэж нэрлэдэг байсан. Тэгээд битүүн хүртэл хураад битүүний орой, шөнө Цэдэрлхамаа хураад маргааш нь шинэлээд тэгээд тардаг байсан. 1-нээс авахуулаад 15 хоног ерөөл эхэлдэг. 3-н хүртэл ерөөгөөд 15 хүртэл Дүд энэ тэр гээд олон ном хурдаг байсан. 15-д хүртэл дүйчин гэдэг шүү дээ. Энэ хугацаанд хурдаггүй өдөр байхгүй. Би 18-тай хар болсон. Тэрнээс хойш хурал удаагүй. Тийм учиртай юм. Тэдний өдөр хурлаа хаасан гэж яг мэдэхгүй байна л даа. Энгэрийн шанданд байсан. Хурал жигтэйхэн хааж байхыг нь санаж байна. Чухам хэдэнд хаасныг нь мэдэхгүй.

Ахай гүний хийд ямар сахиустай байсан бэ?

Улааны шашин, улаан сахиустай байсан. Ловон бадамжунай.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Гол ядам нь ямар бурхан байсан юм бол?

Гол сахиус нь улаан сахиусаа их шүтдэг байсан. Ловон бадам жунай хоёр л байсан даа.Тэгээд Доржсэмбэ гээд бишгүй бий л дээ.

-Жасын талаар, мал хөрөнгө нь хаанаа ямар хүн дээрээ байсан юм бол?

Энгэрийн шандын хурлыг бол Нямжавын Шарав гэлэн гэдэг хүн байгуулсан. Хуучин хурал. Хөдөөдөө хурах хурахгүйтэй байсан юман дээр хэдэн явуулаад Ноён гэгээнээс сүлд залж ирээд Цогчэн хурал байгуулаад нэлээд хөгжиж ирж байсан юм. Улаан сахиус цамтай, 4 азар, 4 мам, 4 хохимой, титэг жад 8, шамба ниржиг гэж 21 дарь эхтэй их том болох гэж байтал тэгээд хурал хаачихсан.

-Энгэрийн шандан дээрээ цам гардаг байсан уу?

Тийм.

-Жамсрангийн бүх дүрүүд нь дээр үед гучин хэдэн дүр гардаг байсан гэсэн. Тэнд бүгд гардаг байсан уу?

Тийм байсан. Улаан сахиусанд лайханги, домормаа тэгээд титэгийн 8 хүүхэд, 4 хохимой, 4 азар, 4 мам. Өшөө юм үгүй шиг санагдаад байна. Өргөжих гэж байсан. Ирэх жил шамба ниржиг 21 Дарь эхтэй болно гэж ярьж байсан юм. Тэгэхийгээд л хурал нь хаачихсан юм.

-Ахай гүний хүрээн дээр цам гарч байсан уу?

Үгүй ээ. Хутагтын хүрээний цамаас улс ирж дэг зааж байсан.

-Өмнө-Дэлгэрийн Хүүхэн хутагтын хийдэд цам гаргадаг байсан гэсэн?

Тийм бүр тэндээс тасарч ирж энд ирж энд цам гаргадаг байсан.

-Ойр хавьд Энгэрийн шанднаас өөр цам гардаг газар байсан уу?

Чойрын цам гэж сонссон. Үзээгүй. Хутагтын цам гээд хэд үзсэн.

- Хутагтын цам томоохон цам байсан уу?

Томоо том.

-Чойрын цам ч том цам байсан гэсэн.

- Энгэрийн шандны жасын тухай?

Жаахан хийд байсан юм. Жасын хэдэн модон гэртэй, дэргэд нь жаахан юмаа хийдэг байр сав дэргэд нь тавьчихсан тийм байсан.

-Хэр мал хөрөнгөтэй байсан юм бол?

Сэтэртэн гээд хонио холбочихоод сэтэр зүүж байгаа гээд их юм болдог байсан юм. Цам гарахын урд баруунтаа Гандаа гэдэг сор залдаг байсан юм. Тэгээд тэрнийгээ өргөтгөөд цам болгосон юм гэнэ лээ.

-Манай судалгаа нь професор Б.Ренчин гуайн 1979 онд эмхтгэсэн судалгаанд дээр тулгуурлаж байгаа юмаа. Тэгээд Дархан сумд арваад хийд байсан гэж тэмдэглэгдсэн байх юмаа?

Байсан байсан. Уулын баруун сугаар Дураалын хурал гэж байлаа. Хойшлоод Элэгний энгэрийн хурал. Цаашлаад Зараа булангийн хурал гэж байсан.

-Зараа булангийн гэдэг чинь яг хийд байсан байна уу? Бид хайгаад олоогүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэр чинь хөдөөний нэг хурал. Жилдээ хэд хоног хураад л тардаг хурал байсан юм. Ганц хоёр байшин байснаас хөдөөх хурал гэдэг чинь их юм байгаагүй ш тээ. Дураалын хурал гээд энэ уулын баруун суганд бас нэг хоёр гурван хурал хурдаг байсан юм. Ихийнх гэж гэж нэг хурал хурдаг, Чого гэж нэг хурал хурдаг, Ганданшадивлан гэж хурал хурдаг байсан. Их олон хурал байсан даа.

-Ахай гүний хүрээ гэдэг нь хамгийн том нь байсан байна. Гурван овоо гэдэг газар Самба лхүндэвийн хийд гэж байсан байна.

Энгэрийн Шанд шүү дээ.

Хараатын хийд гэж байсан байна?

Хараатын хийд гэдэг чинь Сүмийн хийд гэж байсан юм. Том хийд байсан шүү.

-Бас Хавцалын хийд гэж байсан байна.

Миний түрүүнд уулын баруун сугад байдаг гэсний чинь Хавцалын хийд, Дураалын хийд гэж байсан.

-Дээд доод хоёр хавцал байсан уу?

Тийм. Доод хавцалд нь одоо уурхай ухаад байгаа биздээ?

-Арай ухаагүй байна лээ.

Дээд хавцал гэдэг нь урдаа худагтай жаахан талбай бий дээ.

-Хоёулан дээр нь хийд байсан юм уу?

Үгүй ээ доодох дээр нь юу ч байгаагүй. Сүүлдээ нэг суурин байсан байх.

-Бүүрийн хурал гэж байсан байна.

Тийм. Бөөрийн рашааны хурал гэж байсан.

-Тэрийг үзсэн. Дандаа дугуй модон гэр дуганууд байсан бололтой байсан.

Дандаа гэр хэлбэртэй дөрвөн юу босгоод тэрэн дээрээ тооно бариад тэгээд эргэн тойрон унь бариад хийчихдэг.

-Хүйсийн хурал гэж байсан байх юм?

Хүйхийн хурал, Рашааны хурал тун ойрхон байгаа юм байх. Хүйхийн хурал гэдгийг би сайн мэдэхгүй.

-Ганданшадавлин хийд гэж бас байна. Хүйхийн хурлыг ингэж нэрлэдэг байсан гэсэн байна.

Тийм. Ганданшадавлин гэдэг юм.

-Ахай гүний бас Гандан шадавлин тиймээ?

Ахай гүний хийд гэдэг чинь л Ганданшадавлин хийд шүү дээ.

-Цэцэгт дэнж гэдэг нь ямар учиртай юм болоо?

Мэдэхгүй ээ.

-Ахай гүний хийдийн талаар нэг хөгшин сүүлд бас домог ярьж байна лээ. Нэг эрдэмтэй газар шинждэг зурхайч хүн байсан. Тэгээд хэдэн хоногийн дотор Ахай гүний хийдээ нүүлгэхгүй бол их ус гарах нь ээ гээд 3 хоногийн дотор хийдийг нүүлгэ гэхэд нь нүүлгэсэн. Тэгээд дараа нь хуучин хийд байсан газар их ус гарч хийдийг цэцэгт дэнж рүү гаргасан гэдэг гэсэн.

Тэрийг би дуулаагүй ээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Таван толгойн хурал гэж байсан байна. Тэрийг та санаж байна уу?

Хүйхээс зүүн хойд талд Таван толгойн хошуу гэж бий дээ. Тэнд л хурдаг байсан байх л даа. Говийхныг сайн мэдэхгүй ээ. Гурван мандалын хийд гэж байх учиртай.

-Зараагийн гэдгийн хурал гэж байсан байна?

Хүйхээсээ зүүн хойшоо нэг хонхорт байсан.

-Элэгний хурал гэж байсан байна?

Хойно нэг хурал байсан юм. Сүүлдээ тэндээсээ нүүгээд Үетийн хурал нэртэй нэг хэсэг явсан.

-Элгэн гэдэг газар тийм түүрх байдаг гэж хүн зааж өгсөн юм. Элгэн гэдэг газраа байж байгаад урагшаа Үет гэдэг газарлуу нүүсэн юм байна тиймээ?

Тийм.

-Босгоны хурал гэж байсан юм болов уу?

Босгоны хурал гэдэг чинь Энгэрийн шандын хурал явж явж тэнд очоод хурал болсон юм. Зочийн хурал нэмсэн юм. Улаан хошууны хурал ч гэнэ. Босгоны хурал ч гэнэ.

-Босгоны хурал нь Энгэрийн шандны хуралнаас тасарсан хурал байсан уу?

Тийм л байх.

-Ийм хэдэн хурлыг тэмдэглэсэн байна.

Өөр монгол отгуудын хурал гээд бишгүй хурал байсан. Тэр болгон сэтгэлд орохгүй байна.

-Өлгийн хурал, Цагаан эргэний хурал гэж та дуулсан уу?

Өлгийн хурал гэдгийг бол дуулаагүй. Цагаан эрэгний хурал гэж байсан. Чухам Ахай гүний хошуун дээрх хурал бол биш байхаа. Чойр чигээс тасарсан хурал байсан байх. Сүүлд нь хэн билээ дээ дуганыг авсан гэж дуулдсан. Цагаан эрэгний хурал гэж сайн мэдэхгүй ээ. Цэцэн вангийн хошууны хурал байх аа.

-Шавартын хурал гэж ямар хурал байсан юм бол? Шавартын шанданд хурал байсан юмуу?

Миний мэдэхийн лав байгаагүй. Юу ч байгаагүй. Мандалын хүрээнд хурал байсан. Гурван мандалынхаа Дунд мандалын энгэрт байсан. Дэрсэн усанд хурал байсан.

-Хараатын хурлын талаар өөрийн санаж байгаагаа ярихгүй юу?

Сайн мэдэхгүй. Байнгын хуралтай байсан газар. Сүмийн хийд гэж байсан.

Цагаан эрэгт манайхаас тасарсан хурал биш Боржигон сэцэн вангаас ирсэн хурал болж таарах нь уу?

Энийг мэдэх хүн байхгүй байхаа. Сүүлд энд нэг хурал байгуулагдсан бололтой байна лээ. Манайхнаас лам нар ирж сууж байгаагүй байхаа. Чойр зүгийнх байх.

-Энэ Ахай бэйсийн хүрээн дээр төвд лам нар залдаг байсан уу?

Би мэдэхгүй ээ.

-Өөр танд санаж байгаа нэмж хэлэх зүйл байна уу?

Одоо юу ч байхав дээ.

-Та сурч байхдаа ямар дуганд хурдаг байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цогчэн дуганд хурдаг байсан. Жарз нэг жил хийсэн.

-Та хар болсноосоо хойш жарз хийгээгүй юу? Хэдэн удаа жарз хийх ёстой байсан юм?

Хэд ч хамаагүй л хийх ёстой байх байсан л даа.

-108 хоног энэ Ахай гүнийхээ нутгийн хилээр тойрсон уу?

108 хоног гол устай газраар тойрдог юм шүү.

-Одоо жарз хийдэг хүмүүс цөөрсөн байхаа?

Урьд нь ч элбэг л байсан л даа. Чулуун дээр А хийгээд тэгээд хэдэн хүн явна босгочихоод явдаг байсан. Манайх Хулжийн бүрдэд бий. Тэр А үсэг чинь ном заасан хүний тоогоор А үсэг хийдэг юм. Бөөрийн рашаан, Шавартай, Дотуурт байх ёстой.

-Өөр та ноён хутагтын жүдийн талаар ярьж өгөөч?

Өвгөн багш маань жүдийг нь өгчихсөн. Энгэрийн шандны хурал гэдэг чинь лам харгүй хүүхэн шуухангүй л зоч хурал шүү дээ.

-Эмэгтэй лам нар олон байсан уу?

Олон олон. 100 гаруй шавьтай байсан.

-Энгэрийн шандны мяндагтангуудыг мэдэх үү?

Манай багш нар л байсан. Улаан хошуу гэдэг газраас зөөгөөд Энгэрийн шанданд авчирч байсан.

-Өөр улааны шашинтай газар байсан уу?

Дуулаагүй юм байна.

-Дэлгэрхааны Долоодын хийдийг мэдэх үү?

Мэдэхгүй.

-Жодын хуралтай томоохон хийд нь Энгэрийн шандны хийд байсан хийд байсан юм байна?

Тиймээ. 108 гол шанд 108 хүнд тавьдаг газруудаар явна. Энгэрийн Шандны хурал гэдэг чинь эргэдэг гороон зам гэж байдаг шүү дээ, тэрний гадна талд л хүн авчраад тавьчихна. Өглөө босоход энд тэндгүй гар хөл чирсэн нохой явдаг тийм газар байсан. Хүнийг даавуу жийрэгтэй л авчраад тавьчихдаг байсан.

-Дүүгүүртэй явдаг байсан гэсэн?

Зочоч дүүгүүртэй, дүүгүүрдсэн газрынхаа чулуун дээр хийх ёстой байдаг байсан.

-Энгэрийн Шандны хийд хэзээ байгуулагдсан юм бэ?

Шарав гэлэн санаачлан байгуулсан.

-Хурал ном нь байнгын эсвэл онцгой өдрүүдэд хурдаг байсан уу?

Доржсэмбэ, Ягваан, Ямбээ зэрэг онцлох хурал хурдаг байсан. Цогчэн хурал байгуулагдаад өдөр тутам хурдаг болсон. Хийдийн хамба нь их багш Түвдэн багш байсан. Манай эцэг Лувсандоо дэд хамба, унзад нь байсан. Шарав гэлэн эсэргүүнд баригдсан. Би эсэргүүний үед эцгээрээ биш, эхээрээ овоглосон.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА